



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/НТ

Хажуу шинэ үс

Малын эм, тариа вакцин хадгалах хөргүүр
хүлээн авах ажлын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 74 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны 12 дугаар сарын 05-ний өдөр Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газар "Ирээдүй" иргэний бүлэгтэй байгуулсан Засаг даргын Тамгын газрын хур хог хаягдал орчны бохирдлын зардлаас "Малын эм, тариа вакцин хадгалах хөргүүр"-ийг нийлүүлэх ажил үйлчилгээнд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийг хүлээн авах эрх бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд:

Комиссын дарга: Н.Өлзийтогтох (Тамгын дарга)

Гишүүд: Н.Ганбат (Санхүү албаны дарга)

Л.Батбаатар (Өрнөлт багийн Засаг дарга)

А.Бямбадорж (Мал эмнэлгийн тасгийн улсын
байцаагч)

С.Батсайхан

(Ирээдүй бүлгийн ахлагч)

2."Ирээдүй" иргэний бүлэгтэй хүлээн авах ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн нэр төрөл, хэмжих нэгж, тоо ширхэг, хүчин чадал бүрээр нь акт үйлдэн хүлээн авч үндсэн хөрөнгөд бүртгэн авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Нягтлан бодогч (У.Сүнжидмаа) нарт үүрэг болгосугай.

3. Дээрх хөргүүрийн үнэ 8,500,000 (Найман сая таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын Газрын хур хор хаягдал орчны бохирдлын зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Нягтлан бодогч (У.Сүнжидмаа) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

482201117